



НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2012 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/44

Улаанбаатар хот

Олон улсын Хүүхдийн эрхийн
өдрийг тэмдэглэх тухай

Монгол Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6, Нийслэлийн Засаг даргын 2012 оны А/368 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Олон улсын Хүүхдийн эрхийн өдрийн спорт тоглолтын арга хэмжээг 2012 оны 06 дугаар сарын 01-ний өдөр Их жанжин Сүхбаатарын талбайд зохион байгуулсугай.

2. Тэмцээнийг зохион явуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Баг тамирчдын зардалд шаардагдах 500.000 /таван зуун мянга/ төгрөгийг бусад төвлөрсөн арга хэмжээний зардлаас гаргахыг нягтлан бодогч Ж.Цэдэнсодномд зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

113

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
 2012 оны төвдүгээр сарын 20-ны өдрийн
А.Н.Н. тоот тушаалын хавсралт



Олон улсын Хүүхдийн эрхийн өдрийн
 спортын тоглолтын төсөв

№	Зардлын нэр	Дүн
Гудамжны сагсан бөмбөгийн тэмцээн:		
1.	Тамирчдын шагнал: 1-р байр: 2 x 4 хүн x 10.000 ₮ = 80.000 ₮ 2-р байр: 2 x 4 хүн x 8.000 ₮ = 64.000 ₮ 3-р байр: 2 x 4 хүн x 5.000 ₮= 40.000 ₮	344.000
2.	Шүүгчдийн зардал: 4 хүн x 20000 ₮ = 80.000 ₮	
3.	Тээврийн зардал: 2 тал x 40.000₮= 80.000₮	
4.		
Дугуйн уралдаан:		
5.	Тамирчдын шагнал: 1-р байр: 3 хүн x 10.000 ₮ = 30.000 ₮ 2-р байр: 3 хүн x 8.000 ₮ = 24.000 ₮ 3-р байр: 3 хүн x 5.000 ₮= 15.000 ₮	156.000
6.	Шүүгчдийн зардал: 4 хүн x 20000 ₮ = 80.000 ₮	
7.	Диплом=7.000	
НИЙТ ДҮН:		500.000 ₮



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2012 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 4/368

Улаанбаатар хот

Өдөрлөг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны 44 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хүүхэд гэр бүлдээ аз жаргалтай” нэгдсэн өдөрлөгийг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.


2. Олон Улсын Хүүхдийн эрхийн өдрийг угтсан ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Олон Улсын Хүүхдийн эрхийн өдрийг тохиолдуулан “Хүүхэд гэр бүлдээ аз жаргалтай” баярын нэгдсэн өдөрлөгийг 2012 оны 06 дугаар сарын 01-ний өдөр Сүхбаатарын талбайд, нийслэлийн дүүрэг, хороод өөрсдийн нутаг дэвсгэрт тус тус зохион байгуулсугай.

4. Тус өдрийг угтсан ажлууд болон өдөрлөг зохион байгуулахад шаардагдах 16 180 000 /арван зургаан сая нэг зуун наян мянга/ төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гаргахыг Тамгын газар /Ц.Болдсайхан/-т зөвшөөрсүгэй.

5. Төлөвлөгөөнд орсон ажлууд болон өдөрлөгийн үйл ажиллагааг зохион байгуулалтын өндөр түвшинд гүйцэтгэж, шаардлагатай асуудлаар нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудыг татан оролцуулж, хяналт тавьж ажиллахыг Зохион байгуулах комисс /Ц.Цогзолмаа/-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



Г.МӨНХБАЯР

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2012 ОНЫ
05 дугаар сарын 02-ны өдрийн
1368 дугаар захирамжийн нэгдүгээр
хавсралт

150017

**“ХҮҮХЭД ГЭР БҮЛДЭЭ АЗ ЖАРГАЛТАЙ” ӨДӨРЛӨГИЙГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ НИЙСЛЭЛИЙН АЖЛЫН ХЭСЭГ**

- Дарга:** Нийслэлийн Засаг даргын орлогч, нийслэлийн
Хүүхдийн төлөө зөвлөлийн дарга
- Орлогч дарга:** Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
- Гишүүд:** Баянгол дүүргийн Засаг дарга
Сүхбаатар дүүргийн Засаг дарга
Чингэлтэй дүүргийн Засаг дарга
Багануур дүүргийн засаг дарга
Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга
Баянзүрх дүүргийн Засаг дарга
Налайх дүүргийн Засаг дарга
Багануур дүүргийн Засаг дарга
Багахангай дүүргийн Засаг дарга
Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын
Хэвлэл, мэдээллийн албаны дарга
Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны
Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга
Нийслэлийн Цагдаагийн газрын дарга
Замын цагдаагийн газрын дарга
Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга
Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга
Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дарга
Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын дарга
Нийслэлийн Соёл, урлагийн газрын дарга

Нийслэлийн Боловсролын газрын дарга

Нийслэлийн Хот тохижилтийн газрын дарга

UBS телевизийн захирал

Гэрэлтүүлэг, чимэглэл компанийн захирал

Соёлын төв өргөөний захирал

Үндэсний соёл амралтын хүрээлэнгийн захирал

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн Хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн

Нарийн бичгийн
дарга:

Нийслэлийн Хүүхдийн төлөө газрын дарга


Нийслэлийн Засаг даргын 2012 оны
 05 дугаар сарын 22-ны өдрийн
 А/368 дугаар захирамжийн хоёрдугаар
 хавсралт

УХБ

**“ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДӨР”- ИЙГ
 УГТАЖ ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2012.05.10

Д/д	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах байгууллага	Нийслэлийн Хүүхдийн төлөө газраас харицах хүн
1.	Нийслэлийн цэцэрлэгийн багш, арга зүйчдийн дунд “Хүний эрх хүүхдийн эрхээс ..” илтгэл, онол практикийн бага хурал зохион байгуулах, гарын авлага гаргах.	05/16	Нийслэлийн Хүүхдийн төлөө газар, Нийслэлийн Боловсролын газар	Н.Хөхөө
2.	ЕБС-ын сурагчдын дунд “Хотын соёлд миний оруулах хувь нэмэр” зохион бичлэгийн уралдааныг зохион байгуулах.	05/15-25	Нийслэлийн Хүүхдийн төлөө газар, Дүүргүүд	Г.Ариунгэрэл
3.	Б.Явуухулангийн цэцэрлэгт хүрээлэнд яруу найргийн наадам зохион байгуулах.	05/29	Нийслэлийн Хүүхдийн төлөө газар, дүүргүүд	Л.Энхтуул
4.	Хүүхэд, өсвөр үеийг оролцуулсан “Хүүхдийн эрхийн конвенц, хууль тогтоомжоор “АХА” тэмцээнийг зохион байгуулах.	05/26	НЗДТГ-ын Хэвлэл, мэдээллийн алба, НХТГ	Х.Нарангэрэл
5.	ОУ-ын гэр бүлийн өдрөөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд мод тарих. 06 дугаар сарын 01-нд ресторан, кафе, баар цэнгээний газруудад “Би гэр бүлдээ аз жаргалтай” Гэр бүлийн хөтөлбөрт үйлчилгээг явуулах ажлыг зохион байгуулах.	06/01	НЗАА-ны Хүнс худалдаа, үйлчилгээний хэлтэс, Нийслэлийн Хүүхдийн төлөө газар	Л.Энхтуул



ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ НЭГДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

ЗОРИЛГО:

Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг нийслэлийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх, хүүхдийн хөгжил, оролцоо, хүмүүжил төлөвшлийн асуудалд эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх.

Хүүхдийн эрхийн хамгаалах олон улсын өдрийг тэмдэглэх 2012 оны уриа:

“Хүүхэд гэр бүлдээ аз жаргалтай”

ХУГАЦАА:

2012 оны 06 сарын 01-ний өдрийн 11:00-16:00 цагт

ЦАГ, БАЙРЛАЛ:

1. 06-р сарын 01-нд 11:00-16:00 цагт Д.Сүхбаатарын талбайд Хүүхдийн баярын нэгдсэн үйл ажиллагааг зохион байгуулах,
2. 06-р сарын 01-нд 11:00-16:00 цагт дүүрэг тус бүр өөрсдийн нутаг дэвсгэрт хүүхдийн баярын үйл ажиллагааг дүүргийнхээ онцлогт тохируулан, өвөрмөц байдлаар зохион байгуулах,
3. 06-р сарын 01-нд 11:00-16:00 цагт хороо тус бүр өөрийн нутаг дэвсгэрт хүүхдийн баярын үйл ажиллагааг ДЗДТГ-аас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу онцлог хэлбэрээр зохион байгуулах,

Жич: /Сүхбаатарын талбайд зохион байгуулагдах хүүхдийн баярын нэгдсэн арга хэмжээнд Сүхбаатар дүүрэг хамтран оролцоно./

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
- Нийслэлийн Хүүхдийн төлөө газар

ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД:

- Нийслэлийн Хүүхдийн төлөө зөвлөл
- Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар
- Нийслэлийн харъяа агентлаг, газрууд

- Нийслэл, дүүргийн Хүүхдийн холбоо
- Аж ахуйн нэгж байгууллагууд

БАЯРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

НЭГ. ТӨВ ТАЛБАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Төв тайзны үйл ажиллагаа:

- Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд, Шадар сайд, Нийслэлээс сонгогдсон УИХ-н гишүүд, НИТХ-ын дарга, тэргүүлэгчид, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн Төр захиргаа, Хүүхдийн байгууллагын удирдлагууд Сүхбаатарын талбайд тусгайлан зассан суудалд сууна.
- Хүүхдийн баярын нээлт, ёслолын үйл ажиллагаа нь төв тайзан дээр явагдана. /Тайзыг Сүхбаатарын талбайн баруун талд буюу зүүн зүгт харуулан засч, тусгай хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаа явагдана/
- Баярын үйл ажиллагаанд оролцох аж ахуйн нэгж байгууллагууд хуваарилагдсан талбайд хөтбөрт үйл ажиллагаа явуулна.

ХОЁР. ДҮҮРЭГ ТУС БҮР ӨӨРСДИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ЧИГЛЭЛ

2.1 Дүүргийн хэмжээнд

- Сүхбаатарын талбайд зохион байгуулагдах хүүхдийн баярын нэгдсэн арга хэмжээнд Сүхбаатар дүүрэг хамтран оролцоно,
- Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй, Налайх, Багануур, Багахангай дүүргүүд сонгосон талбайд, хороод тус бүр өөрсдийн нутаг дэвсгэрт хүүхдийн баярын үйл ажиллагаагаа зохион байгуулна.
/Сүхбаатар дүүрэг хорооддоо баярын үйл ажиллагааг зохион байгуулах талаар чиглэл өгнө./

2.2 Зохион байгуулалт

- Дүүрэг болон хороонд баярын үйл ажиллагаанд төрийн өндөрлөгүүд, УИХ, Нийслэл, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдийг урин оролцуулах,
- Нийслэлийн Хүүхдийн төлөө зөвлөлөөс Дүүрэг бүрт хувиарлагдсан гишүүдийг татан оролцуулж, хамтран ажиллах,
- Дүүргийн хэмжээнд холбогдох хэлтэс, албадаас бүрдсэн ажлын хэсэг байгуулан ажиллах,
- Дүүрэг тус бүр өөрийн онцлогт тохируулан хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж ажиллах,
- Дүүргийн ЗДТГ-аас хороо бүрт хүүхдийн баярын үйл ажиллагааг зохион байгуулах талаар үйл ажиллагааны чиглэл өгч, үүрэгжүүлэн арга зүйгээр хангаж ажиллах,
- Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг идэвхижүүлэн, дэмжлэг авч ажиллах,
- Дүүргүүдэд үйл ажиллагаа явуулж буй нийтийн хоолны үйлчилгээний газрыг эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүн, хүүхдийн менюгээр үйлчлэх санал тавьж,

дүүргийн үйлдвэрлэл үйлчилгээний хэлтэс, мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт тавиулах,

- Хүүхдийг эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд аж ахуйн нэгж байгууллага бүр баярыг угтсан олон талт ажлыг зохион байгуулах,
- Үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөрийг урьдчилан Нийслэлийн Хүүхдийн Төлөө Газарт 05-р сарын 23-ны дотор ирүүлэх,
- 2012 оны 05 сарын 25-нд НЗД-ын орлогч дарга /Ц.Цогзолмаа/-д үйл ажиллагааны төлөвлөгөө, бэлтгэл ажлын явц, хөтөлбөрийн талаар мэдээлэл хийх,

2.3 Үйл ажиллагааны чиглэлээр

- Хүүхдийг танин мэдэхүй, гоо зүй, ёс зүйн хүрээнд хөгжүүлж, төлөвшүүлэхүйц урлаг, соёл, спортын арга хэмжээг зохион байгуулах,
- Хүүхдүүдэд зориулан явуулах хөгжөөнт үйл ажиллагааг тэдний эрүүл мэнд, осол аюулгүй байдлыг мэргэжлийн түвшинд хангасан байхуйц тоглоом, наадгайгаар үйлчлэн явуулах,
- Хүүхдүүдэд баярын бэлэг, урамшуулалыг гардуулах,
- Хүүхдийн оролцоонд түшиглэсэн өөр бусад төрлийн үйл ажиллагааг шинээр санаачлан зохион байгуулах,
- Үйл ажиллагааг аль болох хүүхдийн эцэг эх, гэр бүлийн гишүүдийг хамруулсан хэлбэрээр зохион байгуулах,

2.4. Хорооны хэмжээнд:

- Дүүргээс өгсөн үүрэг, чиглэл, удирдамжийн дагуу хүүхдийн баярын арга хэмжээг хорооны нутаг дэвсгэрийн хүрээнд онцлог хэлбэрээр зохион байгуулах,
- Хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг үйл ажиллагаанд татан оролцуулах,
- Баярын үйл ажиллагааг аль болох хүнд нөхцөл дэх амьдралын баталгаажих түвшнөөс доогуур орлоготой, нутаг дэвсгэрийн хувьд захын хорооллын, алслагдмал өрхийн хүүхэд багачуудыг хамруулан зохион байгуулах,
- Хүүхдийг танин мэдэхүй, гоо зүй, ёс зүйн хүрээнд хөгжүүлж, төлөвшүүлэхүйц урлаг, соёл, спортын арга хэмжээг цогц хэлбэрээр зохион байгуулах,

Зохион байгуулах комисс

Холбогдох утас: 11322418,

Веб хаяг: www.child.ub.gov.mn



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ
Ц.ЦОЛЗОЛМАА

2012 оны ... сарын ...-ны өдөр

**“ХҮҮХЭД ГЭР БҮЛДЭЭ АЗ ЖАРГАЛТАЙ” ХҮҮХДИЙН БАЯРЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУДАД ӨГӨХ ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ**

Д/д	Хийгдэх үйл ажил	Хугацаа	Хариуцах байгууллага	НХТГ-аас хариуцах хүн
1.	Баярын үйл ажиллагааны захирамж, удирдамж, нэгдсэн хөтөлбөр гаргах	05/15	НХТГ С.Алтанцэцэг	Ж.Шийлэгпүрэв
2.	Төв тайз, чимэглэл	05/31	НХТГ С.Алтанцэцэг	Р.Батсайхан П.Амар Х.Насанболд
3.	Сүхбаатарын талбайн чимэглэлийг нийгмийн салбарын агентлагууд хариуцан чимэглэх /талбай дээр байрладаг 1 шонгоос нөгөө шон хүртэл 34 м зайд, скез хавсаргав/	06/30-31	СБД, НСУГ, НБГ, НБТСГ, НМХГ, НХГ, НХҮГ, НАГ	С.Намжилсүрэн Б.Мандах
4.	Цахилгааны нөөц, эх үүсвэрийг бэлтгэн хариуцах.	05/30	Гэрэлтүүлэг чимэглэл компани Ц.Амгаабазар	Р.Батсайхан
5.	Өдөрлөгийн үеэр галын аюулгүй байдлыг хангах үүднээс галын автомашиныг бэлэн байдалд байлгах.	06/01	НОБГазар Ч.Батбилэг	Р.Батсайхан
6.	Эмнэлгийн үйлчилгээний автомашин байрлуулах, эмнэлгийн ажилтнуудыг хуваарь гарган ажиллуулах,	06/01	Нийслэлийн Эрүүл мэндийн газар С.Туул	Л.Энхтуул
7.	06.01-нд мэндэлсэн хүүхдийн тоо, эмнэлэгийн хаяг, байршлыг тодруулж, энэ талаарх мэдээллийг НХТГ-т өгөх	06/01		Л.Энхтуул
8.	Талбайн худалдаа үйлчилгээний асуудлыг хариуцаж, зохион байгуулах, хүүхэд эцэг эхчүүдэд зориулсан сандал, хогийн сав гэх мэтийг заавал байрлуулсан байх талаар үүрэгжүүлэх.	05/25	ЗАА-ХХҮХэлтэс Ж.Долгормаа	Л.Энхтуул

9.	Баярын зохион байгуулалтын хугацаанд талбайн цэвэрлэгээний асуудлыг хариуцах.	05/28-06/01	Нийслэлийн Хот тохижилтын газар Б.Бямбадорж, Сүхбаатар дүүрэг О.Баярмагнай	Р.Батсайхан
10.	Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдалд хяналт тавих ажлыг зохион байгуулах.	06/01	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар Л.Баямбасүрэн	-
11.	Зочидын хэсэгт хэл татах, цагдаагийн хамгаалалт гаргаж, хэв журмыг сахиулах ажлыг зохион байгуулах, цахилгааны гол үүсгэвэр дээр хамгаалалт гаргах.	05/31-06/01	Нийслэлийн Цагдаагийн газар Ө.Энхтөр	Х.Насанболд
12.	Талбайд автомашинуудыг байрлуулах, байрлалыг тогтоох, зам чөлөөлөх, хаах, хөдөлгөөний нягтралыг сааруулах ажлыг зохион байгуулах.	06/01	Замын Цагдаагийн газар Х.Энхжаргал	Р.Батсайхан
13.	Хүүхдийн эрхийн өдрөөр дүүрэг, хороонд хийгдэж байгаа баярын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, ажлыг зохион байгуулах.	05/25-06/01	НЗДТГ-ын Хэвлэл мэдээллийн алба Д.Сайнбаяр	Х.Нарангэрэл
14.	Баярын шторкийг "UBS" болон бусад телевизүүдэд үнэ төлбөргүй цацуулах	05/25	НЗДТГ-ын Хэвлэл мэдээллийн алба Д.Сайнбаяр	Х.Нарангэрэл
15.	Баярын үйл ажиллагааг Монгол орон даяар шууд дамжуулан олон нийтэд хүргэх.	06/01	МҮНОТВ-ийн Хүүхэд сургалт танин мэдэхүйн редакци	Х.Нарангэрэл
16.	МУ-ын Ерөнхий сайд С.Батболдын баярын үйл ажиллагааны нээлтэнд хэлэх үгийг бэлтгэх, хүргүүлэх	05/28	ЗГХА-ХТГ Ариунтуяа	-
17.	Төрийн ёслолын албанд баярын үйл ажиллагаатай холбоотой бичиг баримтыг /урилга, албан бичиг, удирдамж, талбайн үйл ажиллагаатай танилцах	05/15-05/25		

	маршрут/ хүргүүлэх			
18.	НЗДарга бөгөөд УБ хотын захирагч Г.Мөнхбаярын баярын үйл ажиллагааны нээлтэнд хэлэх үгийг бэлтгэх, хүргүүлэх	06/25	Нийслэлийн Хүүхдийн төлөө газар С.Алтанцэцэг	С.Алтанцэцэг
19.	Нийслэлийн хүүхдийн зуслангийн үйл ажиллагааг сурталчилах, үзэсгэлэн хариуцан зохион байгуулах	06/01	Нийслэлийн Хүүхдийн төлөө газар С.Алтанцэцэг	Н.Хөхөө
20.	Талбайд хүүхдүүдийн дунд зохион байгуулагдах спорт тэмцээнийг зохион байгуулах /Сагсан бөмбөг, дугуй/	06/01	Нийслэлийн Биеийн тамир, спортын газар Ж.Ганболд	Х.Насанболд
21.	Талбайд хүүхдүүдийн дунд зохион байгуулагдах урлаг, соёлын үйл ажиллагааг зохион байгуулах /дуу бижиг гэх мэт/	06/01	Нийслэлийн Соёл урлагын газар	Г.Ариунгэрэл
22.	Талбайд хүүхдүүдийн дунд зохион байгуулагдах гар зургийн уралдааныг зохион байгуулах.	06/01	Нийслэлийн Боловсролын газар Т.Ням-Очир	
23.	Зочид төлөөлөгчдийг талбайн үйл ажиллагаатай танилцах маршрут гаргаж, танилцуулахаар авч явах	06/01	НЗДТГ-НХХ М.Отгонбаяр	П.Амар
24.	Өдөрлөгийн үйл ажиллагаанд оролцох хүндэт зочдын суух талбайг бэлдэх, сандал, хивс /тайз болон коридор/ бэлдэх, байрлуулах, ёслолын үйл ажиллагаа, дууссан үед сандлыг тухайн байгууллагад нь хүлээлгэж өгөх.	06/01	Соёлын төв өргөө Б.Байгальмаа	Р.Батсайхан
25.	Иргэний нийгмийн байгууллагууд, эвсэл хөдөлгөөнүүдийн жагсаал, цуглаанаас сэрэмжлэх.	06/25-06/01	Нийслэлийн Цагдаагийн газар Ө.Энхтөр	-

Боловсруулсан: НХТГ-ын хэлтсийн дарга



/Ж.Шийлэгпүрэв/

“ХҮҮХЭД ГЭР БҮЛДЭЭ АЗ ЖАРГАЛТАЙ” ӨДӨРЛӨГӨӨР МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Д.СҮХБААТАРЫН ТАЛБАЙ ДАХ БАЙГУУЛЛАГУУДАЙ
ТАНИЛЦАХ МАРШРУТ /2012.06.01-НД/

жич: ● тэмдэгээр танилцах
байгууллагуудыг тэмдэглэв.

